

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 29-НЫ ӨДРИЙН 25 ДУГААР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

“Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах,
 бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгавар

2026 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
1	2	3
1. Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй, тогтвортой байх зарчмыг хангаж ажиллах хүрээнд:		
1	1.2.төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”- сонсгол сургалтад албан хаагчдыг хамруулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллахыг музейн удирдлагын зүгээс үүрэг болгосон.
2	1.3.яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;	Байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, цөөлөхтэй холбоотой аливаа шийдвэр гаргаж үйлдэх.
2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:		
3	2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;	www.shilendans.mn цахим системд 38 мэдээ мэдээлэл байршуулахаас 38-ийг хугацаанд нь байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй. www.shilen.gov.mn цахим системд чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-18 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-7 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-29 Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал-3, нийт 57 мэдээллийг ил тодоор мэдээлсэн.
4	2.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж,	1.Авлигатай тэмцэх үйл ажиллагааны сурталчилгааг www.ubmuseum.mn www.ulaanbaatar.erp.mn хуудсуудад тус тус нийтэлсэн. (хандалтын тоо өссөн дүнгээр - 1092) 2.Авлигын тухай хуулийг сурталчлах видео танилцуулгыг

	<p>авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;</p>	<p>https://www.facebook.com/UlaanbaatarCityMuseum хуудсанд нийтэлсэн. Холбоос: https://www.facebook.com/UlaanbaatarCityMuseum/videos/724142486855878/ Музейн www.ubmuseum.mn, facebook, instagram хуудсаар нийт 65,717 хандалт авсан.</p> <p>3. Музейн захирлын 2025 оны А/13 дугаар тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 3 гишүүнтэй байгуулж холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Ёс зүйн сэдэвтэй мэдээ, мэдээллийг цахим хаягаар түгээн 423 хүний хандалт авсан.</p>
--	---	--

“Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгавар

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
1	2	3
1.Төр, засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй, тогтвортой байх зарчмыг хангаж ажиллах хүрээнд		
1	<p>1.1.Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх</p>	<p>Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх зорилгоор музейн мэдээ, мэдээллийг www.ubmuseum.mn, www.shilen.gov.mn болон фэйсбүүк цахим хуудсанд 57 мэдээ, мэдээллийг ил тодоор тогтмол байршуулж байна.</p>
2	<p>1.2.Харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх;</p>	<p>Байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбостой аливаа шийдвэр гаргаагүй болно</p>
3	<p>1.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх</p>	<p>Албан хаагчдад ёс зүйн тухай хууль, хэм хэмжээн ойлголт, мөрдөн ажиллах, урьдчилан сэргийлэх зэрэг танилцуулга сургалт хийхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</p>
4	<p>1.5.Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх</p>	<p>Зайлшгүй гарсан сул орон тоонд нээлттэй ажлын байр зарлаж, ажлын ярилцлага хийж сонгон шалгаруулж авдаг ба аливаа хэлбэрийн дарамт шахалтаас сэргийлж, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж байна.</p>

5	<p>1.6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоодын томилолтын зардал гаргаагүй.</p> <p>Төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээ зохион байгуулаагүй.</p>
<p>2. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр</p>		
6	<p>2.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах:</p>	<p>www.shilendans.mn цахим системд 38 мэдээ мэдээлэл байршуулахаас 38-ийг хугацаанд нь байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй.</p> <p>www.shilen.gov.mn хуудасны хяналт хариуцсан ажилтан хянаж 57 мэдээг баталгаажуулан дүгнэсэн.</p>
8	<p>2.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх. бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх,</p>	<p>Музейн захирлын 2025 оны А/13 дугаар тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 3 гишүүнтэй байгуулж холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</p>
<p>3. Өвөлжилтийн бэлтгэлийг хангах, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой асуудлаар:</p>		
9	<p>3.1.Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, зам, тээврийн осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага, зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо. дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэх:</p>	<p>Улаанбаатар хотын музейн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан ба төлөвлөгөөний дагуу тогтмол хяналт тавин ажиллаж байна.</p>
10	<p>3.4.Өсвөр насны хүүхдүүдийн дунд гарч байгаа улаан бурхан өвчний дэгдэлтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд бууруулах, хяналтад авах. өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах;</p>	<p>Музейн захирлын тушаалаар “Эцэг эхийн байнгийн зөвлөл” байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан ба тус зөвлөлөөс эцэг эхчүүдэд хүүхдээ өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах талаар зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаж байна.</p>

11	4.4.Ажилтны мэдлэг, боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
----	---	---

“Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
1	2	3
1	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврын 1.2 дахь хэсэгт заасны дагуу	Байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргаагүй ажиллаж байна.

Монгол Улсын ерөнхий сайдын “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
1	2	3
1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж зардал хэмнэх талаар	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоодын томилолтын зардал гаргаагүй. Төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээ зохион байгуулаагүй.